

ЦАХИЛГААН ДУГУЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

/ЗАХИАЛГАТ СУДАЛГАА/

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/207

Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг
Хянасан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа
Удирдсан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн ахлах зөвлөх Б.Үүрцайх (Ph.D)
Судлаачид:	Д.Аюуш, Б.Батцэцэг, Б.Ууганжаргал, Т.Эрдэнэчимэг, А.Итгэл, Х.Очир, Б.Оюунчимэг

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ	3
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ	5
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЦАХИЛГААН ДУГУЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДАЛ	5
ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА	11
ИХ БРИТАНИ	11
ГЕРМАН.....	15
АМЕРИК.....	16
КАЗАХСТАН.....	19
ХЯТАД	23
ЯПОН	25
ХАВСРАЛТ	29
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	32

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн захиалгаар “Цахилгаан дугуйн эрх зүйн зохицуулалт: зарим орны туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Цахилгаан дугуй болон Сурроны замын хөдөлгөөнд оролцож буй эрх зүйн зохицуулалтын талаарх Монгол Улсын болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Герман улсын эрх зүйн зохицуулалтыг судлахын зэрэгцээ Америк, Англи, Хятад, Япон, Казахстан зэрэг орнуудыг хамруулж, эдгээр орнуудын цахилгааны дугуй болон сурроны холбогдох эрх зүйн зохицуулалт, тэр дундаа цахилгаан дугуйг хэрэглэх насны хязгаар, хурдны хязгаарын асуудлуудыг авч үзэн, харьцуулан судлав. Мөн Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахилгаан дугуй болон сурроны хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгаа энэ үед энэ асуудлыг хэрхэн зохицуулж, нөхцөл байдал ямар байгаа талаар мэдээллийг оруулав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь үндсэн хоёр хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, Монгол Улсын цахилгаан дугуй болон Сурроны талаарх эрх зүйн орчин, нөхцөл байдлын талаар, Хоёрдугаар хэсэгт, захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаанд авагдсан орнуудын цахилгаан дугуй болон сурроны талаарх эрх зүйн зохицуулалт, нөхцөл байдлын талаарх мэдээллийг тус тус оруулав.

Түлхүүр үг: Цахилгаан дугуй, Суррон

Key words: electric bike, scooter, Sur- Ron

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ

Монгол Улсын цахилгаан дугуйн эрх зүйн зохицуулалт, нөхцөл байдлын тухайд

Монгол Улсын хэмжээнд цахилгаан дугуй (sur-ron)-ыг тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд, залуучууд цахилгаан унадаг дугуй (sur-ron), скүтер, мопед, мотоцикл унаж замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж, зам тээврийн осолд өртөж өөрт болон бусдад эрүүл мэнд, эд материалын хохирол учруулах, бусдын хэвийн аюулгүй зорчих эрхэд нөлөөлөх зэрэг нөхцөл байдал үүсээд байна.

Монгол Улсад замын хөдөлгөөнд оролцоход дараах эрх зүйн орчин, хүрээ үйлчилж байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (*унадаг дугуй, мопедын хувьд “Хорин тав. Унадаг дугуй, мопедоор хөдөлгөөнд оролцоход тавих нэмэлт шаардлага” гэсэн тусгайлсан бүлгээр зохицуулж байна*)
- Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм
- Авто тээврийн тухай хууль
- Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам

Манай улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн зохицуулалтыг илүү нарийвчлан Суррон, Скүтер зэрэг хурд, хүчний хувьд мопед болон мотоциклоос зарим үзүүлэлтүүд нь илүү байна. Иймээс Монгол Улсад үйлчилж буй хууль, эрх зүйн хүрээ, техникийн шаардлага, стандартад нийцүүлэх шаардлагатай. Үүнд: тээврийн хэрэгслийн гэрчилгээ, дугаартай байх, их гэрэл, хажуугийн толь, хурд хэмжигч гэх мэт иж бүрэн тоноглогдсон байх ёстой г.м.

Гадаадын зарим орны цахилгаан дугуйн эрх зүйн зохицуулалтын тухайд

Судалгаанд хамруулсан Их Британи, Герман, АНУ, Казахстан, Хятад, Япон зэрэг орнуудын туршлагаас үзэхэд, эдгээр улсуудад цахилгаан дугуй буюу дугуйн дөрөөг цахилгаан хөдөлгүүрээр дэмждэг дугуй нь хамгийн багадаа 20 км цаг, хамгийн ихдээ 25 км цаг хурдтай байдаг бөгөөд хурдны дээд хэмжүүрт хүрэхээр цахилгаан мотор нь автоматаар унтардаг горимтой байдаг байна. Насны хувьд 14-18 насны хязгаартай байна. Ямар ч тохиолдолд 14-өөс доош насныхан энэ төрлийн дугуйг унах зөвшөөрөл олгодоггүй байна. /Харьцуулсан мэдээллийг хүснэгт 1-ээс үзнэ үү/

Суррон (Sur-Ron)-ы хувьд цахилгаан дугуй гэх ангилалд багтахгүй бөгөөд хурд, хүчний хувьд цахилгаан дугуйнаас даруй 2-3 дахин илүү байдаг байна. Жишээ нь **Их Британид** Сурроныг мотоцикл болон мопед гэж ангилладаг байна. Харин **Америкт** бол Суррон нь эргэх дохио, толь байхгүй учраас мопед эсвэл түүнтэй ижил тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолооны үнэмлэх авах боломж байхгүй. Эдгээр дугуйнууд нь цахилгаан дугуйны гурван ангиллын системд багтахгааргүй хурдан явдаг бөгөөд дөрөөгүй тул цахилгаан дугуй гэж ангилж болохгүй. Үүнээс гадна эдгээр дугуйнууд нь АНУ-д зөвшөөрөгдсөн моторын дээд хүчнээс 2-3 дахин хүчтэй (3000 ватт) мотортой юм. Тиймээс техникийн хувьд эдгээрийн **аль нь ч хууль ёсоор гудамжинд явах эрхгүй** байдаг. Судалгаанд хамрагдсан бусад Герман, Казахстан, Хятад, Япон улсын хувьд цахилгаан дугуй гэх ангилалд Сурроныг авч үздэггүй байна. Учир нь цахилгаан дугуйны хурдны хязгаар болон техникийн шаардлагуудаас Суррон нь илүү юм. Иймээс эдгээр орнуудад мопед болон мотоциклын ангилалд оруулж эрх зүйн болон техникийн шаардлагыг тавьдаг байна.

Судалгаанд авагдсан орнуудын мэдээллийг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

Хүснэгт 1. Улс орнуудын цахилгаан дугуйн талаарх асуудлуудын харьцуулалт

Улс/ мэдээлэл	Насны хязгаар	Хурдны хязгаар	Зорчиж буй зам
Их Британи	14 нас	25 км/цаг	Дугуйн зам болон бусад зам
Герман	14 нас	20 км/цаг	Тусгай тэмдэглэгээ бүхий дугуй зам, дугуй зам байхгүй газар бол авто замын хөдөлгөөнд оролцохдоо авто замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хариуцлагатай оролцоно.
Америк¹	14-18 нас	20-28 миль/цаг	Дугуйн зам /Sur-Ron дугуйн зам болон бусад замаар явах эрхгүй/
Казахстан	18 нас	25 км/цаг /явган хүний зам дээр 6 км/цаг-аас ихгүй/	Дугуйн зам, авто зам, явган хүний зам
Хятад	16 нас	Зам тус бүрт хязгаарыг тогтоосон	Дугуйн зам, орон нутгийн зам, зөвшөөрөгдсөн хот, мужуудын зам
Япон	16 нас	24 км/цаг /явган хүний зам дээр 10 км/цаг-аас ихгүй/	Дугуйн зам, авто зам, явган хүний зам

¹ Хавсралтад муж тус бүрээр дэлгэрэнгүй оруулав.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЦАХИЛГААН ДУГУЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. Хууль эрх зүйн орчин

Монгол Улс 1997 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Монгол Улсын их хурлын тогтоолоор 1968 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Вена хотноо байгуулсан “Замын хөдөлгөөний тухай Конвенц”-ийг хүлээн зөвшөөрч нэгдэн орсноор тус Конвенцод нийцүүлэн хууль, эрх зүйн зохицуулалтыг батлан мөрдөж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн² 4.1-д Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дүрмээр тогтооно;

Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1.1-д Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтооход оршино. Замын хөдөлгөөнтэй холбоотой бусад хэм хэмжээний актууд нь энэ дүрмийн заалт шаардлагууд дээр үндэслэгдсэн, түүнтэй зөрчилдөхгүй байвал зохино гэж тус тус заасан.

Энэхүү Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.1-д “тээврийн хэрэгсэл гэж” хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг, 3.1.2-д “механикжсан тээврийн хэрэгсэл” гэж мопедоос бусад хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг, тус тус хэлэхээр тодорхойлж, Замын хөдөлгөөний дүрмээр мопед, мотоцикл, унадаг дугуй зэргийг мөн тодорхойлж өгсөн. *Тухайлбал:*

1.2.24. “мопед” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр буюу гурван дугуйт тээврийн хэрэгслийг;

1.2.25. “мотоцикл” гэж хөдөлгүүрийн ажлын багтаамж буюу чадал, эсхүл техникийн дээд хурд нь мопедынхоос илүү, хоёр дугуйт механикжсан тээврийн хэрэгслийг. Энд өөрийн жин нь 400 кг (ачааны зориулалттай бол 550 кг)-аас хэтрэхгүй гурван дугуйт болон мотоциклын төрлийн жолооны залууртай дөрвөн дугуйт механикжсан тээврийн хэрэгсэл мөн хамаарна;

1.2.37. “унадаг дугуй” гэж унаж яваа хүний булчингийн хүчээр явдаг (0.25 кВт-аас илүүгүй чадал бүхий цахилгаан хөдөлгүүрээр тоноглогдсон байж болно), хоёроос цөөнгүй дугуйтай (хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрээс бусад) тээврийн хэрэгслийг;) гэж тус тус тодорхойлжээ.

Дээрх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор насны хувьд Замын хөдөлгөөний дүрмийн 2.3-д “А” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 18 нас, 25.3. Унадаг дугуйг 10 хүртэлх насны хүүхэд харгалзах хүнтэйгээр зөвхөн явган хүний зам дээр, харин 10-аас 14 хүртэлх насны хүүхэд явган хүний зам болон түүн дээр тэмдэглэгдсэн унадаг дугуйн замаар унаж хөдөлгөөнд оролцож болохоор, 16 нас хүрээгүй бол мопед жолоодож замын хөдөлгөөнд оролцохыг хориглохоор, 25.4. Унадаг дугуйг 14-өөс, мопедыг 16-аас дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохдоо унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явах бөгөөд ямар тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явж болох, 3.4. в/ мотоцикл, мопед жолоодохдоо хамгаалах малгайг зааврын дагуу өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх зэрэг асуудал тусгагдсан байна.

Унадаг дугуй, мопедын хувьд **“Хорин тав. Унадаг дугуй, мопедоор хөдөлгөөнд оролцоход тавих нэмэлт шаардлага” гэсэн тусгайлсан бүлгээр зохицуулж**, 25.5. Энэ дүрмийн 25.4-т заасны дагуу зорчих хэсгийн захаар байрлан явахад хүндрэлтэй буюу

² Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /legalinfo.mn/mn/detail?lawId=208663

боломжгүй байвал унадаг дугуй, мопед нь хөвөөгөөр, эсхүл унадаг дугуй нь явган хүний замаар явж болох бөгөөд ингэхдээ аюулгүй байдлыг хангаж, хурдыг цагт 10 км-ээс хэтрүүлэхгүй, явган зорчигчдод саад учруулахгүй байвал зохино. Хэрэв явган зорчигчийн хөдөлгөөн ихтэй байвал бууж явгалан, явган зорчигчийн үүргээр хөдөлгөөнд оролцох зэргээр бусад тодорхой зохицуулалтыг тусгасан байна.

Мөн дүрмийн 1.3-т Замын хөдөлгөөнд оролцогч нь аюул, хохирол учруулахгүй, хөдөлгөөнд осолтой байдал бий болгохгүйгээр зорчих, 9.8. Гараар өгөх дохиог бусад хөдөлгөөнд оролцогчдод сайтар харагдахуйц байдлаар гүйцэтгэнэ. Зүүн гар тийш дохио өгөхдөө зүүн гараа хажуу тийш чигээр нь сунгах буюу баруун гараа тохойгоор нь нугалж өргөнө. Баруун гар тийш дохио өгөхдөө баруун гараа хажуу тийш чигээр нь сунгах буюу зүүн гараа тохойгоор нь нугалж өргөх, 14.3. Зогсоолд байрлуулах хэлбэр буюу байршлын хилийг 7.6.а-7.6.и нэмэлт тэмдэг буюу 1.1 тэмдэглэлээр заасан байвал уг тэмдэг, тэмдэглэлийн дагуу тээврийн хэрэгслийг байрлуулж зогсооно. 7.6.б, 7.6.в, 7.6.е-7.6.и нэмэлт тэмдэг бүхий зогсоолд суудлын автомашин, мотоцикл, мопед, унадаг дугуйг зорчих хэсэгтэй хиллэсэн явган хүний зам дээр гаргаж (унуулж) зогсоохыг зөвшөөх, 14.4. Энэ дүрмийн 14.3-т зааснаас бусад газарт болон мөн 7.4.ж нэмэлт тэмдгээр заасан зориулалтын зогсоол байхгүй газарт унадаг дугуй, мопедыг явган зорчигчийн хөдөлгөөнд саад болгохгүйгээр явган хүний зам дээр зогсоохыг зөвшөөрөх, 25.9. д 25.9. Унадаг дугуй, мопедын жолоочид дараах зүйлийг хориглоно:

а/ зам дээр жолоодлогын (унаж сурах) дадлага хийх, сайтар дадлагажаагүй үедээ замын хөдөлгөөнд оролцох;

б/ залуурыг сул тавих, дөрөөнд гишгэхгүй явах;

в/ унадаг дугуй, мопедын овроос уртаашаа буюу өргөөшөө 0.4 м-ээс илүү гарсан ачаа тээвэрлэх;

г/ зорчигчид зориулсан суудалгүй тохиолдолд буюу ачааны зориулалттай тэвшинд хүн тээвэрлэх;

д/ 7 хүртэлх насны хүүхдийг зориулалтын нэмэгдэл суудал, хамгаалах хэрэгсэлгүйгээр тээвэрлэх;

е/ өөрийн үйлдлийг хянах чадваргүй (согтуурсан, мансуурсан гэх мэт) хүнийг тээвэрлэх;

ж/ зориулалтын чиргүүлээс бусад зүйлийг чирэх, тээврийн хэрэгслээр чирүүлэх.

Дүрмийн 5.12. г/ зорчих хэсэг дээр дугуйт тэшүүр, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр явахыг хориглох заалтуудыг тодорхой тусган өгчээ.

Тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага, бүртгэлжүүлэх асуудалтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт, стандарт журмын талаар:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор тус улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинжлэх ухааны холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байна.

21.2.Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна.

21.3.Гадаад улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

21.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно.

21.5.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн хийцийг өөрчилсөн тохиолдолд техникийн хяналтын үзлэг, оношилгоог давтан хийлгэж гэрчилгээ авна. гэж тус тус заасан байна.

Энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхийг өнөөдрийг хүртэл тодорхойлохгүйгээр олон загвар бүхий тээврийн хэрэгслүүд хяналтгүйгээр хөдөлгөөнд оролцох явдал ихсэж байна.

Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандарт нь авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих аюулгүйн шаардлага, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд нөлөөлөх техникийн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох, энэ талаар төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэх зорилготой.

Энэхүү стандартын 13 дэх хэсэгт Мотоциклд тавих техникийн ерөнхий шаардлага болох жолооны механизм, тоормос, цахилгаан тоноглол явах ангийн талаар тусган, Авто тээврийн хэрэгсэл, Мотоцикл.ерөнхий шаардлага MNS 6933:2021 стандартаар мотоциклыг ашиглахад тавих шаардлагыг тогтоож. мотоциклыг бүртгэх, хяналт тавих, ашиглах, байгууллага, хувь хүн мөрдөхөөр тогтоож өгчээ.

Харин манай Улсад мопедод тавих техникийн ерөнхий шаардлага, тухайн төрөлд ямар загвар багтах, хэрхэн ашиглах зэрэг стандарт байхгүй замын хөдөлгөөний дүрмийн 4 дүгээр хавсралтад ашиглахыг хориглох эвдрэл гэмтэл, техникийн зөрчлийн жагсаалтад зарим зүйлийг тусгасан байна.

Авто тээврийн тухай тухай хуулийн зарим зохицуулалтын талаар:³

Энэ хууль нь авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон авто тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, авто тээвэрлэлт болон авто тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Хуулийн 3.1.1."авто тээврийн хэрэгсэл" гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгслийг;

3.1.18."авто үйлчилгээний байгууллага" гэж авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчид үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг.

Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 6.1.11.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

15.1.Авто тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, аймаг, нийслэлийн нийтийн зорчигч тээвэр, таксины үйлчилгээг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5, 5.12-т заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

17¹.2.Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, журмыг авто тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

³ Авто тээврийн тухай тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=29>

Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 дугаартай **"Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"**-ын 3.2.Шинээр бүртгэсэн авто тээврийн хэрэгсэлд улсын бүртгэлийн дугаар, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

Энэхүү журам нь авто тээврийн хэрэгслийн өмчлөх эрх болон бүртгэл хөтлөх, улсын бүртгэлийн дугаар олгох, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой бөгөөд журмын 1.3. Авто тээврийн хэрэгслийг бүртгэхдээ "Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт" MNS ISO 3833:2010 стандартыг баримтална гэж тус тус заажээ.

1.2. Цагдаагийн Ерөнхий Газраас гаргасан дүгнэлт

Аливаа улс орнууд аль нэг улсад үйлдвэрлэсэн нэг төрлийн тээврийн хэрэгслийн загварт зориулж, Замын хөдөлгөөний дүрэм болон бусад эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулахаас татгалзсан чиг хандлагатай байна.

Олон Улсын болон дотоодын нөхцөл байдал эрх зүйн зохицуулалтын хүрээнд скүтер, сур-рон загварын цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгслийг техникийн болон хурдны үзүүлэлтээр унадаг дугуй, мопед, мотоциклийн төрөлд хамруулан ойлгох, тухайн төрлийн хүрээнд тусгагдсан Замын хөдөлгөөний дүрмийн зохицуулалтаар хөдөлгөөнд оролцуулах боломжтой байхаар байна.

Асуудлын гол шалтгаан нь манай Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн зохицуулалтыг бүрэн судлахгүй, нэгдсэн нэг ойлголтод хүрэхгүй, хэрэгжилтийг хангахгүй байгаагаас буюу тухайлбал дээр хөндөгдөж байгаа тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөний дүрэмд тодорхойлсон тээврийн хэрэгслийн төрөлд нь ялгах ажлыг зохион байгуулаагүй, бүртгэлжүүлээгүй, түрээслэгч байгууллагуудад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх, техникийн шаардлагад анхаараагүй зэргээс иргэд олон нийтийн эргэлзээ бий болох, байгууллага хоорондын үл ойлгоцолоос уг асуудал үүсэж байна гэж дүгнэхээр байна.

"Sur-ron" компаниас үйлдвэрлэн нийлүүлж байгаа Light Bee X (даац 70 кг, хурд 75 км/ц, 6000Вт хүчин чадалтай) мотоцикл сонирхогчдын түвшинд, Ultra Bee (хурд 90 км/ц, даац 93 кг, 12500 Вт) болон Storm Bee (хурд 120км/ц, даац 70 кг, 22500 Вт) өндөр хүчин чадал бүхий мэргэжлийн тамирчдад зориулсан 3 төрлийн загварын тээврийн хэрэгслийг техникийн болон хурдны үзүүлэлтээр Замын хөдөлгөөний дүрэмд заасан "Мотоцикл" төрөлд хамааруулж дүрэмд өөрчлөлт оруулахааргүй байна.

Иргэдэд түрээслэх хэлбэрээр үйлчилгээ үзүүлж байгаа болон хувь иргэдийн ашиглаж байгаа Скүтер нь техникийн болон хурдны үзүүлэлтээр 50 хүртэлх км- ээс илүүгүй хурдтай тул "Мопед"-ын төрөлд хамааруулж дүрэмд өөрчлөлт оруулахааргүй байна. Харин техникийн үзүүлэлтээр Мопед болохыг тодорхойлж гэрчилгээжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын хууль, тогтоол, дүрэм, журмаар "нийтийн тээвэр" гэж тодорхойлсон тодорхойлолт одоогоор байхгүй бөгөөд одоогийн нийтэд "мопед, скүүтер"-ыг түрээслэх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд Авто тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Авто тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, аймаг, нийслэлийн нийтийн зорчигч тээвэр, таксины үйлчилгээг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5, 5.12-т заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ" гэж заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргаас холбогдох зөвшөөрлийг авах зохицуулалттай боловч Авто тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгоно:

15.9.1.нийтийн тээврийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон, техникийн хяналтын

үзлэгт хамрагдаж тэнцсэн нийтийн тээврийн хэрэгсэлтэй байх гэж заасан нь дээр дурдсан үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдүүд тавигдах шаардлагад нийцэхгүй байна.

1.3. Цахилгаан хөдөлгүүрт дугуйтай холбоотой статистик мэдээлэл

Манай улсад өнөөдрийн байдлаар “Жэт”-ийн скүтер 6000, “Тапо”-ын скүтер 700, суррон 650 байгаа гэдэг тоог түрээслэгч, нийлүүлэгч байгууллагаас өгөөд байгаа бөгөөд хувь иргэд ямар тоогоор ашиглаж байгаа судалгаа мэдээлэл байхгүй байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд Улсын хэмжээнд мотоциклтой холбоотой зам тээврийн осол 1422 бүртгэгдэж 305 хүний амь хохирч, 733 хүн гэмтсэн бол унадаг дугуйтай холбоотой 357 осол бүртгэгдэж 8 хүн нас барж, 263 хүн гэмтсэн (нийслэлд 224, орон нутагт 39) байна.

Нийслэлд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслээс иргэдийн гол анхаарлыг татаж байгаа скүтер, суррон загварын тээврийн хэрэгсэл холбогдсон 60 (скүтер 28, суррон 32) осол 2023 онд бүртгэгдсэн бол 2024 оны дулааны улирал эхэлсэн 3-5 саруудад 112 осол гарч 75 хүн гэмтсэн байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Яаралтай тусламжийн тасагт:


- 2022 онд нийт 96
- 2023 онд нийт 229
- 2024 оны эхний долоон сарын байдлаар нийт 178 цахилгаан хөдөлгүүрт (суррон)-ы осол гэмтэл бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2. Хоёр дугуйтай тээврийн хэрэгслийн осол гэмтлийн тоо баримт

Он	Осол гэмтлийн тоо	0-18 нас	2 дугуйтай тээврийн хэрэгсэл жолоодон осолд өртсөн иргэдийн тоо
2021	1181	210	67
2022	1452	232	110
2023	1680	310	235
2024	1232	281	238

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам <https://moh.gov.mn/>





Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

ИХ БРИТАНИ

Их Британид нийтийн эзэмшлийн зам болон бусад зам дээрх аюулгүй байдал, дэг журмыг хангаж зохицуулахын тулд цахилгаан унадаг дугуй, мотоцикл, цахилгаан скүтер зэргийн хэрэглээг тус бүрийн онцлогоос нь шалтгаалж тодорхой хууль тогтоомж дүрэм журмаар зохицуулж байна.

Цахилгаан дэмжлэгтэй дөрөөт дугуй буюу цахилгаан дугуй (EAPC-Electrically assisted pedal cycles)

Их Британийн хуулийн дагуу тодорхой шалгуурыг хангасан цахилгаан унадаг дугуйг ердийн унадаг дугуйтай адил гэж үздэг байна. Энэхүү ангилалд багтсан цахилгаан унадаг дугуйг дугуйн зам дээр болон нийтийн зам дээр унах боломжтой бөгөөд ямар нэгэн жолоодох эрхийн үнэмлэх, даатгал, татвар төлөх шаардлагагүй хамгаалалтын малгай өмсөх шаардлагагүйгээр ашиглахыг зөвшөөрдөг байна.

Их Британид цахилгаан дугуйнд дараах хууль ёсны шалгуурууд тавигддаг байна. Үүнд:

Моторын хүчин чадал: Цахилгаан мотор нь 250 ваттаас хэтрэхгүй байх ёстой.

Хурдны хязгаарлалт: Хөдөлгүүр нь зөвхөн 15.5 миль / буюу цаг (25 км/цаг) хүртэлх хурдтай байна. Хэрэв энэ хурд хэтэрсэн тохиолдолд хөдөлгүүр нь автоматаар унтрах ёстой.

Дөрөө: Цахилгаан дугуй нь унадаг дугуйн адил түүнийг хөлөөр хөдөлгөх дөрөөгөөр тоноглогдсон байх ёстой.

Жолоочийн насны хязгаар: 14-өөс дээш насны бүх иргэн дээрх шаардлагыг хангасан цахилгаан дугуйг дугуйн зам дээр унах боломжтой.

Зорчиж буй зам: Дугуйн зам болон бусад зам. Эдгээр цахилгаан унадаг дугуйг "цахилгаан тусламжтай дөрөөт дугуй" (EAPCs) гэж нэрлэдэг. Цахилгаан унадаг дугуйг унахын тулд үнэмлэх авах шаардлагагүй бөгөөд бүртгүүлэх, татвар төлөх, даатгалд хамрагдах шаардлагагүй.

EAPC⁴ дүрэмд нийцээгүй аливаа цахилгаан дугуйг мотоцикл, мопед гэж ангилдаг бөгөөд энэ тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг бүртгүүлж, татвар төлөх шаардлагатай. Мөн унахын тулд жолооны үнэмлэхтэй байх хэрэгтэй бөгөөд ослын хамгаалалтын малгай зэрэг мотоциклд тавигддаг бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Сур-Рон аль ангилалд багтах вэ?

Сур-Рон цахилгаан унадаг дугуй нь техникийн үзүүлэлтүүд, моторын хүч, хурдны хувьд Их Британийн хуулийн дагуу цахилгаан унадаг дугуйны ангилалд багтдаггүй, харин мотоцикл гэж ангилагдана. Өнөөдрийн байдлаар Их Британид дараах загварын Сур-Рон-ыг ашиглагдаж байгаа бөгөөд, эдгээр загвар бүр нь Их Британид зөвшөөрөгдсөн байна.

⁴ EAPC-Electrically assisted pedal cycles

1. Sur-Ron Light Bee L1E болон LBX



2. Sur-Ron Ultra Bee



3. Sur-Ron Storm Bee



Эдгээр Sur-Ron загварууд нь Их Британид хууль ёсны зөвшөөрөгдсөн бөгөөд гэхдээ моторын хүчин чадал, хурд нь EAPC буюу Цахилгаан дэмжлэгтэй дөрөөт дугуйн ангилалд багтах шаардлагыг хангаагүй гэсэн үг юм. Тэгэхээр Сур-роныг Их Британид мотоцикл буюу мопед гэж үздэг байна. Энэхүү төрлийн Сур-роныг унахын тулд мотоцикл буюу моторт тээврийн хэрэгсэл болгон бүртгүүлж, даатгуулж, татвар (Тээврийн хэрэгслийн онцгой албан татвар) төлсөн байх ёстой. Мотоциклийн жолоочид зохих жолооны үнэмлэх шаардлагатай бөгөөд мотоциклийн хамгаалалтын малгай өмсөх шаардлагатай.

Мөн Сур-роны тоормосын стандарт нь Британи/Европ/Олон улсын стандарт BS EN ISO 4210-2:2014 буюу түүнтэй адилтгах Европын стандартын 4.6.8-д нийцэж, үр ашигтай ажиллах горимд хадгалагдах ёстой.

Дүгнээд хэлбэл Сур-рон нь мотоцикл болон мопед тавигдах шаардлагуудыг хангасан байх ёстой бөгөөд үүнд тээврийн хэрэгслийн дугаартай байх, их гэрэл, хажуугийн толь, хурд хэмжигч гэх мэт иж бүрэн тоноглогдсон байх ёстой.

Мопед жолоодох үнэмлэхтэй 16-аас дээш насны хэн ч ашиглах боломжтой бөгөөд зам дээр 30 миль / цаг хүртэл хурдтай жолоодох боломжтой бөгөөд замын хязгаарыг 45 миль / цаг хүртэл нэмэгдүүлсэн. Жолооч нь 16-аас дээш настай, тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагаас олгосон жолоодох үнэмлэхтэй, мопед жолоодох Үндсэн сургалтын гэрчилгээтэй байх ёстой.

Их Британид цахилгаан дэмжлэгтэй дугуй болон мотоцикл, мопедийн ангилал, жолоодох эрхийн үнэмлэхийн ангилал, насны хязгаарыг доорх хүснэгтээр харуулав:

Хүснэгт 3. Ангилал, насны хязгаар

Тээврийн хэрэгсэл	Олгох үнэмлэхийн ангилал, төрөл	Жолоодох эрхийн үнэмлэхэд тавигдах шаардлага	Жолоочийн насны хязгаар
25 км/ц-аас 45 км/цагийн хурдтай мопед	AM	Үндсэн сургалтын гэрчилгээтэй, онолын шалгалт, бүх хөдөлгүүртэй 2 дугуйт мопед дээр жолооны дадлагын шалгалт өгсөн байх ёстой	16
Жижиг 3 дугуйт (50 см хүртэл ба 4 кВт-аас доош)	AM, CBT	онолын шалгалт, жолоодлогын дадлагын шалгалт өгсөн байх	16
Хөнгөн 4 дугуйт (350 кг-аас бага жинтэй, дээд хурд 45 км/цаг)	AM, CBT	онолын шалгалт, жолоодлогын дадлагын шалгалт өгсөн байх	16
2 эсвэл 3 дугуйт мопедтой адил дээд хурд нь 25 км/ц	Q	AM-ангиллын үнэмлэхтэй тохиолдолд олгоно	16-аас дээш
Хөнгөн мотоцикл 11 кВт хүртэл (мөн хүч жингийн харьцаа нь кг тутамд 0.1 кВт-аас ихгүй)	A1	CBT, онолын тест, практик туршилт	17
Стандарт мотоцикл 35 кВт хүртэл (мөн хүч жингийн харьцаа нь кг тутамд 0.2 кВт-аас ихгүй), мотоцикл нь түүний хүчнээс хоёр дахин их тээврийн хэрэгслээс гаргаж болохгүй	A2	Онолын болон дадлагын шалгалт өгсөн байх A1 ангиллын мотоцикл 2 жил жолоодсон үнэмлэхтэй, бусад шаардагдах ахисан түвшний шалгалтуудыг өгч тэнцсэн байх	19
Хэмжээ/хүчний хязгаарлалтгүй, хажуугийн тэрэгтэй эсвэл дугуйгүй мотоцикл, 15 кВт-аас дээш хүчин чадалтай гурван дугуйт мотоцикл	A	Онолын болон дадлагын шалгалт өгсөн байх A2 лицензийг дор хаяж 2 жил эзэмшсэн байх - Дадлагын шалгалтыг (21 ба түүнээс дээш насанд өгсөн байх)	24 настай байх

E-Scooter- Цахилгаан Скутер

Их Британид цахилгаан скутер ашиглахыг хуулиар зөвшөөрдөг, гэхдээ цахилгаан скутерийг хэрхэн ашиглах талаар нарийвчлан заасан шаардлагын дагуу ашиглах боломжтой. Мөн Их Британид иргэн нь цахилгаан скутер худалдаж авахыг хуулиар зөвшөөрсөн бөгөөд та өөрийн цахим скутерийг зөвхөн хувийн эзэмшлийн газар ашиглах боломжтой. Энэ нь таны эзэмшиж буй газар эсхүл зөвшөөрөл авсан бусдын эзэмшил газар, эсхүл зөвшөөрөл авсан өөр газар байж болно. Хэрэв дараах шаардлагыг хангаагүй бол цахим скутерийг зам болон нийтийн газар ашиглах нь хууль бус юм.

- Цахилгаан скутерийн даатгалд хамрагдсан байх
- Цахилгаан скутер нь гэрэл, улсын дугаартай байх
- Цахилгаан скутер нь техникийн үзлэгт бүрэн хамрагдсан
- Цахилгаан скутер-ийн татвар төлсөн

Хэрэв иргэн цахилгаан скутертэй замын хөдөлгөөнд оролцохдоо дээрх шаардлагыг дагаж мөрдөхгүй бол хууль бусаар цахилгаан скутер унаж байна гэсэн үг.

Гэхдээ хэрэв иргэн түрээсийн цахим скутер, өөрөөр хэлбэл төрийн дэмжлэг үзүүлэх туршилтын бүсүүдэд заасан газар нутагт түрээсийн цахим скутер унаж байгаа бол тэдгээрийг нийтийн эзэмшлийн газар дээр хууль ёсоор унаж болно.

2023 оны 12-р сарын 5-наас цахим скутер түрээслэх тухай шинэ хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд хэрэв иргэн цахилгаан скутер дугуй түрээслэх бол түрээслэгчдээ дараах зүйлийг өгөх ёстой гэж заасан.

- Скутер түрээслэгчийн нэр
- Жолооны үнэмлэхний дугаар
- Жолооны үнэмлэхийн урд талын зураг

Эдгээр мэдээллийг цахим скутер түрээсэлдэг бизнес эрхлэгч нь хадгалдаг бөгөөд шаардлагатай бол цагдаад өгч болно. Ингэснээр тэдэнд аюултай, болгоомжгүй цахилгаан скутер жолоодогчийг илрүүлэх боломжийг олгодог бөгөөд эдгээр жолоочийг нийтийн зам дээр цахим скутер жолоодохыг хориглох ёстой. Мөн 17-оос доош насны хүмүүсийг цахим скутер түрээслэхийг зогсоосон.

Хэрэв 2024 онд Их Британид цахим скутерийг хууль ёсны болговол аюулгүй жолоодох, замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжууд гарч ирэх бөгөөд энэ хууль нь одоогийн байдлаар Тээврийн хороо болон Засгийн газрын дэмжлэгийг авч байгаа юм байна. Эдгээр бүс нутагт цахим скутер түрээслэхийг хуульчилсан шалтгаануудын нэг нь уур амьсгалын хямралын үр дагаврыг арилгахад туслах явдал байв. Цахилгаан скутер туршилтын талбай нь нийтийн хариуцлагын даатгалтай тул нийтийн эзэмшлийн талбайд түрээсийн цахим скутер унахыг хуулиар зөвшөөрсөн. Англид нийтдээ 23 цахим скутер туршилтын талбай байдаг бөгөөд эдгээрийг Тээврийн яам 2020 оны 7-р сард эхлүүлсэн. Эдгээр бүс нутагт скутер унахын тулд иргэн Q ангиллын жолооны үнэмлэхтэй байх ёстой.

Лондон бол мөн цахилгаан скутер унах боломжтой цахим скутер туршилтын бүс юм. Иргэн цахим скутер унахын тулд жолооны үнэмлэхтэй байх шаардлагатай. Бусад дүрмүүдээс гадна та дараах зүйлийг баталгаажуулах ёстой.

- Нэгээс илүү хүн скутер унахгүй байх
- Явган хүний замаар бүү яв
- Архи, согтууруулах ундаа хэрэглээгүй байх
- Хурдны зам руу орохгүй байх

2023 оны 6-р сарын байдлаар 1269 удаа цахилгаан скутер мөргөлдөж, 1355 хүн бэртсэн бөгөөд долоон хүн амь үрэгдсэн байна.

ГЕРМАН

Герман улс нь замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай 1968 оны Венийн Конвенц, мөн эдгээр Конвенцийн нэмэлт болох 1971 оны Женевийн хэлэлцээрүүдэд нэгдэн орсон байдаг. Иймээс энэ улсын Замын хөдөлгөөний хууль дүрэм европын замын хөдөлгөөний хууль дүрэм замын дохио, тэмдэгийн системд бүрэн нийцдэг байна. Олон улсын туршлагаас харахад хуулийн хариуцлага хүлээх насны хязгаар бол 18 нас байдаг бөгөөд дэлхий нийтийн нас баралтын тэргүүлэх 10 шалтгаанд зам тээврийн осол багтдаг. Иймд зам тээврийн ослоос сэргийлэх хүрээнд хүүхдүүдийг сурронтой замын хөдөлгөөнд оролцоход хязгаарлалт зайлшгүй шаардлагатай гэж үзэн “Дугуйн хуулийг” улс орнууд санаачлан хэрэгжүүлж байна.

Эрх зүйн зохицуулалт

Европын холбоо болон ХБНГУ-н Замын хөдөлгөөний тухай хууль дүрэмд 13 хүртэлх насны хүүхдүүд зөвхөн явган хүний замаар эцэг, эхийнхээ хараа хяналт дор унадаг дугуй унаж болно. Орон сууцны дунд бол тоглоомын талбай дээр, гэр хороололд тохиолдолд хашаандаа унахыг зохицуулалтаар зөвшөөрдөг.

Харин 14-өөс доош насныхан унадаг дугуй унаж бие дааж хөдөлгөөнд оролцохыг тусгайлан хориглосон байдаг.

Европын холбоо болон ХБНГУ-н 2002/24Е удирдамжийн⁵ дагуу цахилгаан дөрөөтэй дугуй (ЕРАС) нь Хурдны хүч нь 25 км цаг хурдлах эсвэл дөрөө зогсох үед моторын тусламжийг аажмаар тасална. Энэ нь унаж яваа хүний аюулгүй байдлыг хангахаас гадна явган зоригч болон бусад тээврийн хэрэгсэл жолоодогч нарын аюулгүй байдлыг хангахад оршиж байна.

Суррон болон цахилгаан дугуйны хүч чадлыг 250 ваттаас ихгүй чадалтай мотортой байх тухай Холбооны бүгд Найрамдах Герман Улсын тусгай цахим дугуйн хуульд суррон дугуй болон цахилгаан дугуйны талаар маш тодорхой заасан байна.

ХБНГУ бол бүх дугуйчдын зам, тэдгээрийн эрх зүйн орчныг сайжруулах тал дээр анхаарч нийгэмд шинээр үүссэн нөхцөл байдлыг байнга судлан тодорхойлсны үр дүнд Дугуйн тухай хуулийг тусгайлан гаргажээ. Дугуйчдад хамгийн ээлтэй хууль, эрх зүйн орчинтой улсын нэг бол ХБНГУ юм.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед унадаг дугуй, цахим дугуй илүү түгээмэл болж, борлуулалт, эргэлтийг нэмэгдүүлэхэд хүргэсэн. Энэ нь давуу тал болон сөрөг талууд аль аль нь байгаа хэдий ч нийгэмд үүсээд байгаа асуудлыг зохицуулж ХБНГУ хууль, эрх зүйн орчноо сайжруулж, хариуцлагын тогтолцоог хуульчлах зүй шаардлага үүссэн. Германы унадаг дугуйн хуулийг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд дугуйчин нь машин жолоодохтой адил тул Дугуйн хууль болон жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулиуд өөрчлөлт оруулсан байна.

ХБНГУ-д цахилгаан дугуйг “Хувийн хөнгөн цахилгаан тээврийн хэрэгсэл” гэж үздэг бөгөөд дуулгатай бол дээд хурд нь 20км цаг хэтрэхгүй явахыг зөвшөөрдөг байна.

ХБНГУ-ын Дугуйн хуулийн таван үндсэн зарчим

1. Даатгал, бүртгэл

Даатгалын болон дугаарын тэмдэг нь заавал байх ёстой бөгөөд цахилгаан унадаг дугуйны моторын хамгийн их хүч нь 500 ВАТТ байна. Хэрвээ Суррон дугуй бол 20 км цаг байна. Бүх төрлийн дугуй эзэмшигч нарыг заавал дугуйн замаар зорчих ёстой, гэхдээ зам байхгүй тохиолдолд авто замаар хурдны хязгаар хэтрүүлэхгүй зорчихыг зөвшөөрдөг байна. Мөн 16

⁵ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A32002L0024> Directive 2002/24/EC of the European Parliament and of the Council of 18 March 2002 relating to the type-approval of two or three-wheel motor vehicles and repealing Council Directive 92/61/EEC (Text with EEA relevance)

наснаас дээш насны хүүхдүүдийг цахилгаан дугуй, Суррон зэрэг дугуй унаж хөдөлгөөнд оролцохыг хориглодог байна.

2. Согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсэн үедээ дугуй унахаас зайлсхийх энэ нь ХБНГУ-д дугуйн тухай хуулийн маш чухал заалтад тооцогддог.

“Согтууруулах ундаа мансууруулах бодис, эмийн нөлөөн дор дугуй унахыг хатуу хориглоно. Хэрвээ дугуй унаж яваа иргэн согтуурч, мансуурсан үедээ дугуй унасан бол Эрүүгийн тухай хуулиар хариуцлага хүлээдэг байна.

3. Бүх төрлийн дугуй унахдаа гар утсаар ярихгүй байх,
Хэрэв энэ дүрмийг дагаж мөрдөөгүй дугуй унаж байх үедээ гар утсаа ашигласан бол Дугуйн хууль болон зохих хууль, журмын дагуу торгууль ноогдуулна.

4. Дугуй унаж байгаа зоригч заавал дугуйн замаар явах бөгөөд дугуйн зам байхгүй тохиолдолд замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хөдөлгөөнд оролцоно.

Дугуйн зам нь ихэвчлэн замаас хашлагатай тусгаарлагдсан, хучилтын өргөтгөл өөр хээ, өнгөтэй эсхүл будсан унадаг дугуйн тэмдэглээтэй замаар зорчино. Дугуйн замаар яваагүй авто замын хөдөлгөөнд санаатайгаар оролцсон бол тухайн дугуй эзэмшигчид хариуцлага ноогдуулан торгодог байна.

5. Хурдны зам, авто зам дээр дугуй унахаас зайлсхийх ХБНГУ-д хурдны зам, авто зам дээр дугуй унахыг хуулиар хориглодог.

Цахим дугуй нь замын түгжрэлийг бууруулахад том хувь нэмэр оруулсан төдийгүй байгаль орчин ээлтэй болохыг дэлхийн улс даяар баталж байна. Герман улс Цахим дугуйн ашиглалтын тухай хууль тогтоомждоо нийцүүлэн жолоочийн хариуцлагын даатгалыг тусгаж өгсөн нь онцлогтой. Цахим дугуйн ашиглалтын тухай хууль нь Замын хөдөлгөөний ерөнхий хуулийг баримтлан онцлох заалтыг оруулж өгсөн байна. Үүнд: Замын тэмдэг, дохио, хурдны хязгаарлалтыг шинэчлэн оруулсан бөгөөд хэрвээ зөрчсөн тохиолдолд Фденсбургт (Германы жолоочийн онооны систем)-н дагуу 3-15 еврогийн хооронд торгууль оногдуулж, жолоочийн онооноос хасдаг байна. Эдгээр оноо хасагдсанаар цаашид жолоодох эрхээ хасуулах зэрэг шийтгэл оногдуулдаг байна.

АМЕРИК

АНУ-д цахилгаан дугуйг Хэрэглэгчийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын хороо зохицуулдаг. Цахилгаан дугуй нь дөрөө, шөнийн цагаар ажилладаг урд болон хойд гэрэл, дуут дохио эсвэл хонх зэрэг тоног төхөөрөмжийн тодорхой шаардлагыг хангасан байх ёстой.

Цахилгаан дугуйн ангиллын хамгийн түгээмэл загвар болох цахим дугуйн гурван ангиллын системийг АНУ-ын 36 мужид ашигладаг. Энэ системийн дагуу мотор нь 750 ватт хүртэл хүч гаргах чадалтай аливаа цахилгаан дугуйг дараах байдлаар ангилдаг:

- 1-р ангилал - Дугуйн хурд цагт 20 миль хүрмэгц мотор нь унтардаг, зөвхөн дөрөө дэмжих системтэй цахилгаан дугуй.
- 2-р ангилал - Дугуйн хурд цагт 20 миль хүрмэгц мотор нь унтардаг, тохируулагч болон дөрөө дэмжих системтэй цахилгаан дугуй.
- 3-р ангилал - Дугуйн хурд цагт 28 миль хүрмэгц мотор нь унтардаг, зөвхөн дөрөө дэмжих системтэй цахилгаан дугуйнууд.

Цахилгаан дугуй унахад жолооны үнэмлэх шаардлагатай эсэх талаар хууль тогтоомж нь муж болгонд өөр өөр байдаг бөгөөд эдгээр мужууд цахим дугуй унахдаа жолооны үнэмлэхтэй байхыг шаарддаг. Эдгээр нь Алабама, Аляска, Коннектикут, Хавай, Луизиана, Массачусетс, Миссури, Нью Жерси, Нью Мексико, Хойд Дакота, Баруун Виржини, Висконсин мужууд юм.

Одоогоор цахилгаан дугуйн бүртгэл шаарддаг цөөхөн муж байдаг бөгөөд эдгээр нь Алабама, Аляска, Массачусетс, Миссури, Нью Мексико, Висконсин, Хойд Дакота мужууд юм.

Цахилгаан дугуй унахад дуулга өмсөх хатуу шаардлага тавьдаг мужууд бол Коннектикут, Жоржиа, Айдахо, Нью-Йорк юм. Мөн Делавэр (18-аас доош), Хавай (15-аас доош), Охайо (16-аас доош) мужуудад нас харгалзан дуулга өмсөх шаардлага тавьдаг.

Зарим мужуудад цахилгаан дугуй унахад насны хязгаарлалт байдаг. Арканзас мужид 10-аас доош настай иргэдийг цахилгаан дугуй унахыг хориглоно. Жоржиа мужид 15-аас доош настай бол 3-р ангиллын цахилгаан дугуй унаж болохгүй. Хавай мужид 15-аас доош насны иргэдийг цахилгаан дугуй унахыг хориглодог. Индиана мужид 15-аас доош насны дугуйчид 3-р ангиллын цахилгаан дугуй унахыг хориглодог бөгөөд 18-аас доош насны дугуйчид дуулга өмсөх шаардлагатай. Мэйн мужид 16-аас доош насны дугуйчид 2, 3-р ангиллын цахилгаан дугуй унахыг хориглодог бөгөөд 16-аас доош насны дугуйчид дуулга өмсөх шаардлагатай. Мэрилэнд мужид 16-аас доош насны дугуйчдыг 3-р ангиллын цахилгаан дугуй унахыг хориглоно. Мичиган мужид 14-өөс доош насны дугуйчдыг 3-р ангиллын цахилгаан дугуй унахыг хориглодог бөгөөд 18-аас доош насны дугуйчид дуулга өмсөх шаардлагатай.

Sur-Ron, E-Ride Pro, Segway, Talaria зэрэг компаниудын гаргадаг дугуйнууд нь хөнгөн жинтэй цахилгаан бартаат замын дугуйнууд юм. Эдгээр дугуйнуудад эргэх дохио, толь байхгүй учраас мопед эсвэл түүнтэй ижил тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолооны үнэмлэх авах боломж байхгүй.

Мөн эдгээр дугуйнууд нь аль ч ангиллын цахилгаан дугуй биш тул хотын гудамжинд явж болохгүй. Эдгээр дугуйнууд нь цахилгаан дугуйны гурван ангиллын системд багтахгааргүй хурдан явдаг бөгөөд дөрөөгүй тул цахилгаан дугуй гэж ангилж болохгүй. Үүнээс гадна эдгээр дугуйнууд нь АНУ-д зөвшөөрөгдсөн моторын дээд хүчнээс 2-3 дахин хүчтэй (3000 ватт) мотортой юм. Тиймээс техникийн хувьд эдгээрийн аль нь ч хууль ёсоор гудамжинд явах эрхтэй цахилгаан дугуй биш юм.

АНУ-ын зарим мужуудын цахилгаан дугуйн талаарх зохицуулалтууд

Калифорни

Цахилгаан дугуй нь Калифорнийн тээврийн хэрэгслийн хуулиар тодорхойлогддог. Үүнд "цахилгаан дугуй" гэж гурван ангилалд хуваасан 750 ваттаас бага хүчин чадалтай, бүрэн ажиллагаатай дөрөө, цахилгаан мотороор тоноглогдсон унадаг дугуй гэж тодорхойлсон байдаг.

Цахилгаан дугуй нь тээврийн хэрэгсэлд хамаарах бүртгэл, лиценз, даатгалын шаардлагад хамаарахгүй. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох талаарх хууль үйлчилнэ. 3-р ангиллын цахилгаан дугуй унахад дуулга өмсөх шаардлагатай. 16-аас доош насны иргэд 3-р ангиллын цахилгаан дугуй унаж болохгүй.

Цахилгаан дугуй үйлдвэрлэгчид болон борлуулагчид цахилгаан дугуй бүрд түүний ангиллыг харуулсан шошгыг ил тод харагдах газарт наасан байх шаардлагатай. Хэрэв хэрэглэгч цахилгаан дугуйн хурдны хүчин чадлыг нь өөрчилсөн тохиолдолд ангиллыг харуулсан шошгыг солих ёстой.

Колорадо

Колорадо мужид цахилгаан дугуйг: "Хамгийн ихдээ 750 ватт хүч чадалтай, дээд талдаа цагт 20 милийн хурдтай мотортой бөгөөд 2 эсвэл 3 дугуй, дөрөөтэй байх ёстой" гэж шаарддаг.

Хууль ёсны дагуу бага хүч чадалтай цахилгаан дугуйг явган зорчигчийн зам, дугуйн зам дээр ашиглахыг зөвшөөрдөг боловч цахилгаан дугуйн моторыг дугуйн болон явган зорчигчийн замд ашиглахыг хориглодог.

Цахилгаан дугуй нь тээврийн хэрэгсэлд хамаарах бүртгэл, лиценз, даатгалын шаардлагад хамаарахгүй. 21-ээс доош насны иргэд 3-р ангиллын цахилгаан дугуй унахад дуулга өмсөх шаардлагатай. 16-аас доош насны иргэд 3-р ангиллын цахилгаан дугуй унаж болохгүй.

Массачусетс

2022 оны 11-р сарын 8-ны өдрөөс эхлэн Массачусетс муж цахилгаан дугуйн 1, 2-р ангиллыг ашиглаж байна.

Цахилгаан дугуй унадаг хүмүүс жолооны үнэмлэхтэй байх шаарддаггүй бөгөөд унадаг дугуйтай холбоотой бүх эрхийг эдэлдэг. Цахилгаан дугуйг явган зорчигчийн зам болон ихэнх байгалийн гадаргын замаар явахыг хориглоно.

Цахилгаан дугуй үйлдвэрлэгчид болон борлуулагчид цахилгаан дугуй бүрд түүний ангилал, дээд хурд, моторын хүчин чадлыг харуулсан шошгыг ил тод харагдах газарт наасан байх шаардлагатай. Хэрэв хэрэглэгч цахилгаан дугуйн хурдны хүчин чадлыг нь өөрчилсөн тохиолдолд ангиллыг харуулсан шошгыг солих ёстой.

Моторт дугуй гэдэг нь 1, 2-р ангиллын цахилгаан дугуйны тодорхойлолтод хамаарахгүй, цилиндрийн багтаамж нь 50 шоо сантиметрээс ихгүй, автомат хурдны хайрцагтай, дээд тал нь 30 милээс илүүгүй хурдлах чадвартай туслах мотортой дөрөөтэй дугуй эсвэл дөрөөгүй моторт дугуйг хэлнэ.

Моторт дугуйг Цэцэрлэгт хүрээлэнгийн газраас тогтоосон нийтийн эзэмшлийн зам болон бусад нийтийн эзэмшлийн талбайд унахыг хориглоно. Моторт дугуйг унадаг дугуйн зам дээр унаж болно.

